



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/176

Хэрлэн сум

Засварын ажлуудын гүйцэтгэчийг
сонгон шалгаруулах ажлын хэсэг
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих Архивын тасгийн барилгын дотор засвар, Нэгдсэн эмнэлэгийн яаралтай хүлээн авах хэсгийн засварын ажлуудын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Б.Дарханбаатар	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Мягмар-Ариунаа	Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа х ариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Б.Содбилэг	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Ажлын хэсгийн дарга (Б.Дарханбаатар) -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ